

Аудит хийх үндэслэл: Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Аймгийн ИТХТ-ээс хувьчилж, худалдах тогтоол гарсан орон нутгийн өмч, хөрөнгө эзэнгүйдсэн байдалтай байна.

ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ



АГУУЛГА

Аудитын
тайланг
бэлтгэсэн:

Төв аймаг дахь
Төрийн аудитын
газар

Дарга,
тэргүүлэх
аудитор
Ц.Хишигжаргал

Аудитын
менежер
О.Амаржаргал

Ахлах аудитор
Д.Пүрэвсүрэн
Аудитор
О.Сосор
Ч.Загдсүрэн

2017 оны 08 дугаар
сарын 18

Уг тайланг АГ-ын
Веб сайтаас үзнэ
үү.
www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл
байвал 70273463
дугаарын утас,
70272582 дугаарын
факсаар харилцана
уу.

ХАЯГ: Төв аймгийн
Төрийн захиргааны
II байр

Товчилсон үгийн тайлбар

3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

4

БҮЛЭГ 1. Аймгийн ИТХ-аас орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1 Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор шийдвэрлүүлэх үл хөдлөх хөрөнгийн саналын баримт нь бүрдэл дутуу байхад шийдвэр гаргажээ.

6

1.2 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоолуудын хэрэгжилт хангалтгүй байна.

8

БҮЛЭГ 2. 2013-2016 онуудад хувьчлагдсан орон нутгийн өмчийн орлогын 21.7 хувь нь төвлөрсөн байна.

2.1 2013-2016 оны орон нутгийн өмч хувьчлалаар нийт 1185.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 21.7 хувь буюу 257.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.2 Өмч хувьчлалын орлогын дутуу төлөлт буюу 931.3 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна.

12

2.3 Аймгийн ИТХТ-ээс хувьчилж, худалдах шийдвэр нь гарсан орон нутгийн өмч, хөрөнгө эзэнгүйдсэн байдалтай байна.

17

Дүгнэлт

Зөвлөмж

18

19

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт**Аудитын зорилт:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн өмчийн харилцаа, эрх зүйн зохицуулалтын хүрээнд аймгийн ИТХ-аас орон нутгийн өмч, хөрөнгийг хувьчлах, худалдахаар гаргасан шийдвэрийн дагуу хувьчлагдаж, худалдагдсан өмч хөрөнгийн орлого төвлөрүүлэлтийн байдлыг шалгаж, хурлын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

-Орон нутгийн өмч хөрөнгийг хувьчлах, худалдах талаар гарсан аймгийн ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилт

-Өмч хувьчлалын орлого төвлөрүүлэлтийн байдал

Аудитын хамрах хүрээ:

Аудитад 2013-2016 оны аймгийн ИТХ болон аймгийн Орон нутгийн Өмчийн газар, Санхүү төрийн сангийн хэлтсийн өмч хувьчлалтай холбоотой баримт материал, хөрөнгийн данс бүртгэл, хөрөнгийн ашиглалт, тооцоо, судалгаа болон холбогдох бусад баримт материалыг шалгахгаар төлөвлөсөн. Гэвч аудитын явцад Орон нутгийн өмчийн газраас ирүүлэх зарим баримт буюу 2013, 2014 оны орон нутгийн өмчийг худалдах, хувьчлах баримтууд, 2013-2015 оны дуудлага худалдааны баримтууд нь байхгүйгээс төлөвлөгөөний дагуу бүрэн шалгагдсангүй.

Үндсэн мэдээлэл:

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг хувьчлах, худалдан борлуулахад “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль болон “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах” журмын дагуу байгууллагын ӨХБЗ-ийн санал, дүгнэлтийг үндэслэн аймгийн ИТХ-д танилцуулагдан, шийдвэрлэгддэг байна.

Аймгийн орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн судалгаагаар аймгийн ИТХТ-ийн 2013 онд нэг удаагийн тогтоолоор 19.2 сая төгрөгийн, 2014 онд дөрвөн удаагийн тогтоолоор 79.6 сая төгрөгийн, 2015 онд хоёр удаагийн тогтоолоор 26.5 сая төгрөгийн, 2016 онд 3 удаагийн тогтоолоор 498.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдах буюу хувьчлах шийдвэр гарчээ.

Эрсдлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам /2009 он/

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Д.Пүрэвсүрэн, аудитор О.Сосор, Ч.Загдсүрэн нар хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2017 оны 6 дугаар сарын 15-нд эхэлж, 8 дугаар сарын 29-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Орон нутгийн өмч хөрөнгийг хувьчлах, худалдах талаар гарсан аймгийн ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилт

Бүлэг 1

Аймгийн ИТХ-аас орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1 Орон нутгийн өмч хөрөнгийг хувьчлах, худалдах асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхдээ хууль, журмын холбогдох заалтыг бүрэн хангаж байна уу?


Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор шийдвэрлүүлэх үл хөдлөх хөрөнгийн саналын баримт нь бүрдэл дутуу байхад шийдвэр гаргажээ.

Аймгийн ИТХ-аас гаргасан орон нутгийн өмчийг худалдах, хувьчлах шийдвэрүүд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, “Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль, аймгийн ИТХ-ын 2009 оны 02 тоот тогтоолоор батлагдсан “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ыг үндэслэн тогтоол, шийдвэр гаргадаг байна.

2013-2016 онуудад нийт 15 удаагийн тогтоолоор 1175.2 сая төгрөгийн 157 техник хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийг худалдах шийдвэр гарчээ.

	Он	Тогтоолын тоо	Хувьчлах буюу худалдах хөрөнгийн тоо	Үнийн дүн
1	2013 он	4	51	521.3
2	2014 он	4	22	79.6
3	2015 он	3	29	33.7
4	2016 он	4	55	540.6
		15	157	1175.2

Аймгийн ИТХТ-аас орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гаргасан шийдвэрүүдийг графикаар харуулвал:



Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө худалдах, шилжүүлэх, сэлбэг болгон ашиглах, устгах тухай саналаа тухайн шатны Засаг даргад хүргүүлж, аймаг, сумын ИТХ-аар шийдвэрлүүлж ажиллахаар хууль, журамд тусгажээ. Аймгийн ИТХ-аас акталж, худалдах шийдвэр гарсан 157 хөрөнгийн 933.7 сая төгрөгийн 30 орон сууц, 118.2 сая төгрөгийн 110 техник хэрэгсэл, 123.3 сая төгрөгийн 17 барилга, байгууламж байна.

/үнийн дүнгээр/



Аудитад 2015 он, 2016 оны тухайн шатны ИТХ, сумын Засаг даргаас аймгийн ИТХ-д шийдвэрлүүлэхээр ирүүлсэн худалдах, хувьчлах техник хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийн холбогдох баримтыг шалгалаа. Шалгалтаар 2016 оны 1 сард гарсан аймгийн ИТХТ-ийн 14 тоот тогтоолоор шийдвэрлэгдсэн зарим шийдвэрүүдэд зөрчил илэрлээ. Үүнд:

-Зуунмод сумын ЗДТГ-ын данс бүртгэлд 2012 онд бүртгэгдсэн 9.9 сая төгрөгийн мах борлуулах цэгийн барилгыг үлдэгдэл өртөг 8.9 сая төгрөгөөр акталж, худалдах шийдвэр гарчээ. Зуунмод сумын ИТХ-аас тус барилгыг худалдах тухай саналыг ирүүлсэн боловч шийдвэрлүүлэх эд хөрөнгийн саналд ирүүлэх материалын бүрдлийг дутуу ирүүлж, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор 8.9 сая төгрөгөөр худалдах шийдвэр гаргасан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2009 оны 02 тоот тогтоолоор батлагдсан “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ын 5.3.6.5-д “Үл хөдлөх хөрөнгийг актлахаар аймагт саналаа ирүүлэхдээ газар дээрхи болон газар доорхи барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон худалдах...” зэрэг асуудлыг судлан тооцож саналдаа тусгасан байна. Шийдвэрлүүлэх эд хөрөнгийн саналд:

-Данснаас хасах эд хөрөнгийн одоогийн чанар байдлын талаар танилцуулга, тодорхойлолт

-Барилга байгууламжийн хувьд газар эзэмшлийн гэрээ, гэрчилгээ, мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн акт, байгууллагын ӨХБЗ болон техникийн комиссоос гаргасан дүгнэлт,

-Худалдах доод үнийн санал

Дээрхи баримтын бүрдэл дутуу нөхцөлд асуудлыг тухайн шатны ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг хориглоно” гэсэн заалт зөрчигдсөн байна.



Мах борлуулах цэгийн барилга

-Эрдэнэсант сумын “Алтан тулга” ОНӨҮГ-ын 1970 онд ашиглалтад орсон уурын зуухны барилгын үлдэгдэл өртөг 5.3 сая төгрөг /21.2-15.9/ бөгөөд Үнэлгээний компаний хийсэн үнэлгээгээр уг барилгыг 10.3 сая төгрөгөөр үнэлсэн байна. 2015 онд сумын ИТХ-аас уг барилгыг 10.0 сая төгрөгөөр акталж, худалдах саналыг аймгийн ИТХ-д ирүүлсэн боловч 18.6 сая төгрөгөөр худалдах шийдвэр гарсан байна. Энэ нь “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ын 5.3.6.5-д “шийдвэрлүүлэх эд хөрөнгийн саналд худалдах доод үнийн саналаа ирүүлнэ” гэсний дагуу сумын ИТХ, Засаг даргаас тус хөрөнгийг үнэлүүлж, худалдах доод үнийн саналаа ирүүлсэн боловч барилгын үнийг 8.6 сая төгрөгөөр өсгөж шийдвэрлэсэн байна.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор шийдвэрлүүлэх зарим үл хөдлөх хөрөнгийн саналын баримтын бүрдэл дутуу, мөн үнэлгээг тогтоосон хөрөнгийн худалдах доод үнийг тооцоо судалгаа, үндэслэлгүйгээр нэмж шийдвэрлэсэн байна.

1.2 .Орон нутгийн өмч, хөрөнгийг хувьчлах, худалдах талаар гарсан ИТХ-ын тогтоол бүрэн хэрэгжиж байна уу?

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоолуудын хэрэгжилт хангалтгүй байна.

2013-2016 онуудад нийт 15 удаагийн тогтоолоор 1175.2 сая төгрөгийн 157 техник хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийг акталж, худалдах шийдвэр гарчээ. Үүнд:

- 933.7 сая төгрөгийн 30 орон сууц,
- 118.2 сая төгрөгийн 110 техник хэрэгсэл,
- 123.3 сая төгрөгийн 17 барилга, байгууламж байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 34-т “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа

1.Дуудлагаар худалдах

2.Уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/ аргыг хэрэглэнэ, “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ын 5.3.4.1-д “Эд хөрөнгө нь тухайн байгууллагын хувьд илүүдэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэх ашиглахад үр ашиггүй болсон боловч цаашид зориулалтаар нь болон зориулалтыг нь өөрчлөх, засаж сэлбэх зэргээр өөр бусад этгээд ашиглах боломжтой байвал дуудлагаар худалдах”-аар заажээ.

Аудитад 2013-2016 онуудын төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоолуудын хэрэгжилтийг шалгахад 2013-2015 онуудад дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулсан баримт байхгүй байна. Холбогдох байгууллагууд буюу Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Орон нутгийн өмчийн алба болон аймгийн ЗДТГ-ын архиваас орон нутгийн өмчтэй холбоотой баримт, материалыг үзэж, шалгаад аудитын газарт мэдэгдэх тухай албан тоот хүргүүлэхэд дараахь хариуг ирүүлсэн.





Аймгийн ИТХТ-ийн хурлын тогтоолоор акталж, худалдахаар шийдвэр нь гарсан нийт 295.4 сая төгрөгийн 23 автомашиныг худалдах доод үнэ 23.3 сая төгрөгөөр худалдахаар 2016 оны 3 сард дуудлага худалдааг зохион байгуулсан байна. Үүнээс худалдах доод үнэ нь 15.7 сая төгрөгөөр тогтоогдсон 14 машин дуудлага худалдаагаар 21.4 сая төгрөгөөр зарагдаж орлогыг төвлөрүүлсэн байна.



Дуудлага худалдаагаар зарагдсан автомашин

Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 90 тоот тогтоолоор 550.0 сая төгрөгөөр 11 айлын орон сууц худалдан авах шийдвэр гарч 48.6 сая төгрөгийн 2 байрыг аймгийн ЗДТГ-т бүртгэн авч, мөн 95 тоот тогтоолоор 457.8 сая төгрөгийн 9 байрыг хувьчлах шийдвэр гарсан бөгөөд нийт 555.0 сая төгрөгийн 11 орон сууцыг худалдан авсан нь аймгийн ИТХТ-ийн тогтоолоос 5.0 сая төгрөгөөр илүү гарчээ. 2016 оны 31 тоот тогтоолоор орон сууцны талбайн зөрүүгээр үнийг бууруулж 397.9 сая төгрөгөөр,

үнийн зөрүү болох 59.9 сая төгрөгөөр барилгын доорхи авто машины зогсоолыг орон нутгийн өмчид бүртгэж авахаар шийдвэрлэсэн боловч одоог хүртэл данс бүртгэлд бүртгэгдээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоолуудын хэрэгжилт хангалтгүй байна.


Өмч хувьчлалын орлого төвлөрүүлэлтийн байдал

Бүлэг 2 **2013-2016 онуудад хувьчлагдсан орон нутгийн өмчийн орлогын 21.7 хувь нь төвлөрсөн байна.**

2.1 Орон нутгийн өмчийг худалдах, хувьчлах ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн төсөвт орох орлогыг бүрэн төвлөрүүлж байна уу?

2013-2016 оны орон нутгийн өмч хувьчлалаар нийт 1185.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 21.7 хувь буюу 257.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аймгийн Төрийн сан банк дахь “өмч хувьчлалын орлого”-ын дансанд 2013-2016 онд нийт 393.5 сая төгрөг төвлөрсөн байна. Тус орлогын дансанд төвлөрсөн орлогыг шалгалтанд хамрагдсан 2013-2016 оны аймгийн ИТХТ-ийн тогтоолын түүвэртэй тулган шалгаж үзэхэд 257.5 сая төгрөгийн орлогыг тодорхой болгож, үлдсэн 136.0 сая төгрөг нь хэдэн онд, хэн гэдэг иргэн, ямар хөрөнгө худалдан авч мөнгө тушаасан болохыг нотлох баримт байхгүй, холбогдох мэргэжилтнүүдээс тодруулсан боловч тухайн үед өмчийн асуудал хариуцаж байсан ажилтнууд байхгүйгээс нотлогдох боломжгүй байна.



Аймгийн аудитын газарт ирүүлсэн баримтаар 2013-2016 онуудад аймгийн ИТХТ-ийн тогтоолоор худалдах доод үнэ нь тогтоогдсон 157 техник хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийн 1175.2 сая төгрөг, дуудлага худалдааны үнийн зөрүү 9.9 сая төгрөг, нийт 1185.1 сая төгрөгийн орлогыг өмч хувьчлалаас оруулахаас 257.5 сая төгрөг буюу 21.7 хувийн орлогыг төвлөрүүлсэн байна.

2.2 Өмч хувьчлал болон худалдсаны орлогын дутуу төлөлт, өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан уу?

Өмч хувьчлалын орлогын дутуу төлөлт буюу 931.3 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн “Орон нутгийн өмч хөрөнгийг шийдвэрлэсэн ИТХурлын тогтоолын хэрэгжилт судалгаа”-гаар 2009-2012 оны өмч хувьчлалын орлогын дутуу төлөлт буюу авлага нь 260.3 сая төгрөг байна.

Аудитад хамрагдсан 2013-2016 оны өмч хувьчлалын орлогын авлага нь 671.0 сая төгрөг, 2009-2016 онуудын авлага 931.3 сая төгрөг байна.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны “Хөрөнгө шийдвэрлэж, хувьчлах хөрөнгийн жагсаалт батлах тухай” 53 тоот тогтоолын 6-р хавсралтаар 2010 оны 30 тоот тогтоолоор худалдах доод үнэ нь тогтоогдсон боловч өнөөдрийг хүртэл худалдан борлуулагдаагүй байгаа 186.6 сая төгрөгийн 10 байгууламжийн үнийг 50 хувиар бууруулж 93.3 сая төгрөгөөр хувьчлах доод үнийг тогтоосон байна. Уг үнийн зөрүүг хасч тооцвол нийт авлага 838.0 сая төгрөг болж байна.

Эдгээр өр авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна.

2.3 Өмч хувьчлал болон худалдсаны орлогын дутуу төлөлт, өр авлагыг барагдуулсан уу?

Аймгийн ИТХТ-ээс хувьчилж, худалдах шийдвэр нь гарсан орон нутгийн өмч, хөрөнгө эзэнгүйдсэн байдалтай байна.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор хувьчлагдаж, худалдагдахаар шийдвэрлэгдсэн хөрөнгийн талаархи баримт, материал, судалгаа, тайлан мэдээ байхгүй, хэнд ямар хөрөнгийг худалдан, борлуулсан нь тодорхойгүй, орлогын дансны хуулгаар хэн юуны мөнгө төлөөд байгаа нь тодорхойгүй, одоогийн ажил хариуцаж буй мэргэжилтнүүд нь тодорхой мэдээлэл байхгүй, өмнөх ажилтнууд нь ажлаасаа түр чөлөөлөгдсөн байна. Мөн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байгаа зэрэг шалтгаануудаас харахад аймгийн ИТХТ-ийн тогтоолоор хувьчилж, худалдах шийдвэр нь гарсан орон нутгийн өмч, хөрөнгө эзэнгүйдсэн байдалтай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор шийдвэрлүүлэх үл хөдлөх хөрөнгийн саналын баримтын бүрдэл дутуу, мөн үнэлгээг тогтоосон хөрөнгийн худалдах доод үнийг тооцоо судалгаа, үндэслэлгүйгээр нэмж шийдвэрлэсэн байна.

2. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоолуудын хэрэгжилт хангалтгүй байна.

3. 2013-2016 оны орон нутгийн өмч хувьчлалаар нийт 1185.1 сая төгрөгийн орлогыг өмч хувьчлалаас оруулахаас 257.5 сая төгрөг буюу 21.7 хувийн орлогыг төвлөрүүлсэн байна.

4. Өмч хувьчлалын орлогын дутуу төлөлт буюу авлагыг данс бүртгэлд тусгаагүй, хувьчлагдсан хөрөнгийн талаархи баримт, мэдээ судалгаа байхгүй зэргээс харахад аймгийн ИТХТ-ээс хувьчилж, худалдах шийдвэр нь гарсан орон нутгийн өмч, хөрөнгө эзэнгүйдсэн байдалтай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, ОНӨАлбаны дарга Д.Батжаргал нарт зөвлөх нь:

1.Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор шийдвэрлүүлэх үл хөдлөх хөрөнгийн саналын баримтын бүрдүүлэлтийг хууль журмын дагуу бүрдүүлж хэвшүүлэх.

2.Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг акталж, худалдахаар гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоолуудын хэрэгжилтэнд хяналт тавьж цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажиллах .

3.2009-2016 оны орон нутгийн өмч хувьчлалын авлага болох 931.1 сая төгрөгийг барагдуулах, ажлыг зохион байгуулж, зөрчлийг арилган, орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх.

4. Өмч хувьчлалын орлогын эзэн тодорхойгүй 136.0 сая төгрөгийн орлогыг тодорхой болгож, дутуу төлөлт буюу авлагыг аймгийн төсвийн нэгдсэн тайлан, данс бүртгэлд тусгаагүй байгаа зөрчлийг арилгах

5.Өмнөх онуудад хувьчлагдаж, худалдагдахаар шийдвэрлэгдсэн боловч одоог хүртэл үнэ нь төлөгдөөгүй байгаа хөрөнгүүдийн жагсаалтыг гаргаж, бүрэн бүтэн байдлыг хянан үзэж, үнэ бууруулах буюу актлах шийдвэрийг гаргуулах.

Тайлан бичсэн: Ахлах аудитор
Аудитор
Аудитор

Д.Пүрэвсүрэн
О.Сосор
Ч.Загдсүрэн

Тайланг хянасан: Менежер
Дарга,
Тэргүүлэх аудитор

О.Амаржаргал
Ц.Хишигжаргал

Холбогдох байгууллагын санал



41100, Зуунмод, Төв аймэг
Утас: 70273025, Факс: 70272237

2017.03.07 № 05/1931
талай -ны № -т

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу "Өмч хувьчлалын орлого төвлөрүүлэлтийн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлт төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангаар гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.



САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ю.БЯМБАЦОГТ

02 1170

My doc: -2017 on/ A5 тоот-3

**ТӨВ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273539, Факс: 70273579

2017.09.11 № 545
танай 2017.09.04 -ны № 1/928 -т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагын "2013-2016 оны өмч хувьчлалын орлого төвлөрүүлэлтийн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн зөвлөмж, дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид аймгийн ИТХТ-ийн тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангуулахаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ
МЕНЕЖЕР БӨГӨӨД ДАРГЫН ТҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ЗОРИГОО



000000303